

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/7/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargal.ts@audit.mn

Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Бэйкер Тилли Далайван Аудит ХХК
Ерөнхий захирал: Ц.Жигдэн
Утас: 7000-5401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
З.МӨНХЗУЛ ТАНАА

2024.02.29 № 07/606

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны эцэст төслийн үйл ажиллагаа 73.4 хувийн гүйцэтгэлтэй, нийт 16.24 сая ам.доллар буюу 48,373,923.0 мянган төгрөгийн зээлийн ашиглалт гарснаас барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалтад 85.4 хувийг, төслийн удирдлага болон зөвлөх үйлчилгээнд 12.6 хувийг, бусад зардалд 2.0 хувийг тус тус зарцуулсан байна.

Архангай аймгийн төвд баригдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажлыг гүйцэтгэх БА-1 Багц 1 дугаартай гэрээний хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссан ба ажлын гүйцэтгэл нь 50 хувьтай байсан. Гүйцэтгэгчээс төсөлд ирүүлсэн гэрээг сунгах хүсэлтийг холбогдох байгууллагуудад уламжилсан боловч гэрээг цуцлах шийдвэрийг гаргасны дагуу төсөл хэрэгжүүлэгч нэгжээс гүйцэтгэгчийн өнгөрсөн хугацаанд хийсэн гүйцэтгэлийг үнэлж, төлбөр тооцоог эцэслэх ажлыг 2023 онд зохион байгуулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Дундговь, Дорнод болон Ховд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдийн барилга, байгууламжийг ашиглалтанд оруулахаар тус аймгуудад 2023 онд байгуулагдсан комиссын 04/2023, 02/2023 болон БУА-09/2023 тоот дүгнэлтээр төвийн барилга, байгууламжийг хүлээлгэн өгч, ашиглалтад бүрэн оруулсан байна.

Дархан-Уул, Дундговь, Дорнод, Ховд болон Хөвсгөл аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвүүдийг тусгай зориулалтын тавилга, тоног төхөөмжөөр бүрэн тохижуулан төслөөс хүлээлгэж өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл тайлант хугацаанд үндсэн 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 70.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----------|--|--------------------------|--------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 30,507,259,132.75 | 47,150,759,413.42 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 720,382,626.83 | 1,287,665,282.50 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 720,382,626.83 | 1,287,665,282.50 |
| 3121 | Төгрөг | 23,099,895.84 | 637,256,459.47 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 23,099,895.84 | 637,256,459.47 |
| 3122 | Гадаад валют | 697,282,730.99 | 650,408,823.03 |
| 31224 | Төрийн сангийн харилцах | 697,282,730.99 | 650,408,823.03 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 4,995,799.99 | 543,244,548.26 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 4,995,799.99 | 543,244,548.26 |
| 36 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 29,781,880,705.93 | 45,319,849,582.66 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө | 29,781,880,705.93 | 45,319,849,582.66 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 122,517,015.35 | 98,957,388.89 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 122,517,015.35 | 98,957,388.89 |
| 392 | Биет хөрөнгө | 122,517,015.35 | 98,957,388.89 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 152,730,000.00 | 152,730,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (56,001,000.00) | (71,274,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,125,366.00 | 54,125,366.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (45,648,202.65) | (51,049,687.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,851,420.00 | 28,851,420.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,540,568.00) | (14,425,710.00) |
| 39301 | Программ хангамж | 7,150,000.00 | 7,150,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (7,150,000.00) | (7,150,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 30,629,776,148.10 | 47,249,716,802.31 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,366,677,492.54 | 3,240,932,919.02 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,366,677,492.54 | 3,240,932,919.02 |
| 413 | Өглөг | 1,366,677,492.54 | 3,240,932,919.02 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 128,666.68 |
| 4136 | Бусад өглөг | 1,366,677,492.54 | 3,240,804,252.34 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,366,677,492.54 | 3,232,991,812.26 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | - | 7,812,440.08 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 29,263,098,655.56 | 44,008,783,883.29 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 29,263,098,655.56 | 44,008,783,883.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 10,315,141,332.44 | 29,263,098,655.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 18,947,957,323.12 | 14,745,685,227.73 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 30,629,776,148.10 | 47,249,716,802.31 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|----------|--|--------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 21,237,371,647.78 | 15,732,402,267.66 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 21,237,371,647.78 | 15,732,402,267.66 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,000,166,838.69 | 14,518,402,801.76 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 18,996,550,509.63 | 14,517,388,123.76 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 18,996,550,509.63 | 14,517,388,123.76 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 284,800.00 | 264,678.00 |
| 120009 | Бусад орлого | 3,331,529.06 | 750,000.00 |
| 1223 | Тусламжийн орлого | 2,237,204,809.09 | 1,213,999,465.90 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 2,237,204,809.09 | 1,213,999,465.90 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,498,962,685.86 | 970,610,633.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,498,962,685.86 | 970,610,633.94 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,498,962,685.86 | 970,610,633.94 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 520,519,824.99 | 416,098,993.49 |
| 210101 | Үндсэн цалин | 520,519,824.99 | 416,098,993.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,548,522.48 | 52,012,374.19 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,411,070.21 | 13,843,674.29 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,898,700.00 | 4,584,858.33 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,512,370.21 | 4,684,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 4,574,475.96 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,951,779.00 | 40,320,149.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,951,779.00 | 40,320,149.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,855,817,446.43 | 424,312,300.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,351,626,555.51 | 377,224,180.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 19,500,000.00 | 35,000,000.00 |
| 201804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,907,272.00 | 134,048.00 |
| 201806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 481,405,588.66 | 11,867,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 378,030.26 | 87,072.50 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,714,042.75 | 24,023,142.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,765,527.39 | 463,516.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,948,515.36 | 23,559,626.47 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 18,738,408,961.92 | 14,761,791,633.72 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 209,548,580.06 | - |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 209,548,580.06 | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 218.86 | 16,106,405.99 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 218.86 | 16,106,405.99 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 209,548,361.20 | (16,106,405.99) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 18,947,957,323.12 | 14,745,685,227.73 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-----------|--|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 961,806,061.53 | 1,692,598,349.31 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 961,806,061.53 | 1,692,598,349.31 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 961,806,061.53 | 1,692,598,349.31 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 958,474,532.47 | 1,691,848,349.31 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 958,474,532.47 | 1,691,848,349.31 |
| 120009 | Бусад орлого | 3,331,529.06 | 750,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,794,903,581.86 | 841,743,040.36 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,794,903,581.86 | 841,743,040.36 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,794,903,581.86 | 841,743,040.36 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 520,519,824.98 | 401,973,260.92 |
| 210101 | Үндсэн цалин | 520,519,824.98 | 401,973,260.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,548,522.48 | 58,197,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,548,522.48 | 53,017,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 5,180,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,411,070.21 | 11,406,375.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,898,700.00 | 4,831,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,512,370.21 | 4,574,475.96 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,750,000.00 | 2,684,340.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,750,000.00 | 2,684,340.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 22,458,545.00 | 36,544,889.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,458,545.00 | 36,544,889.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,172,215,619.19 | 330,937,174.48 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,813,691.06 | 3,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 19,500,000.00 | 35,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 157,272.00 | 134,048.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 481,405,588.66 | 12,907,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 378,030.26 | - |
| 210813 | Зөвлөх үйлчилгээний зардал | 666,961,037.21 | 279,896,126.48 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (833,097,520.33) | 850,855,308.95 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 226,793,175.49 | 267,002,730.28 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 226,793,175.49 | 267,002,730.28 |
| 220001 | Барилга байгууламж | 149,658,910.76 | 267,002,730.28 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 77,134,264.73 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (226,793,175.49) | (267,002,730.28) |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 209,548,580.06 | - |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 16,106,407.00 |
| 250006 | Бусад зардал | 3,765,527.39 | 463,516.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 205,783,052.67 | (16,569,923.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(7) | (854,107,643.15) | 567,282,655.67 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,574,490,269.98 | 720,382,626.83 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 720,382,626.83 | 1,287,665,282.50 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|------------------------------------|--------------------------|--|
| 2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | | 10,315,141,332.44 | 10,315,141,332.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | 10,315,141,332.44 | 10,315,141,332.44 |
| Тайлант үеийн үр дүн | | 18,947,957,323.12 | 18,947,957,323.12 |
| 2022 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | | 29,263,098,655.56 | 29,263,098,655.56 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | 29,263,098,655.56 | 29,263,098,655.56 |
| Тайлант үеийн үр дүн | | 14,745,685,227.73 | 14,745,685,227.73 |
| 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл | | 44,008,783,883.29 | 44,008,783,883.29 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|--|--------------------------|--------------------------|-----------------------|-------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 16,112,347,500.0 | 15,147,998,526.99 | 964,348,973.01 | 94.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,709,047,500.00 | 999,614,629.46 | 709,432,870.54 | 58.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,709,047,500.00 | 999,614,629.46 | 709,432,870.54 | 58.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 402,100,000.00 | 401,973,260.92 | 126,739.08 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 402,100,000.00 | 401,973,260.92 | 126,739.08 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,260,000.00 | 58,197,000.00 | 12,063,000.00 | 82.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,017,000.00 | 53,017,000.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,180,000.00 | 5,180,000.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,216,800.00 | - | 3,216,800.00 | 0.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 804,200.00 | - | 804,200.00 | 0.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,042,000.00 | - | 8,042,000.00 | 0.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,462,000.00 | 11,406,375.96 | 55,624.04 | 99.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,850,000.00 | 4,831,900.00 | 18,100.00 | 99.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,612,000.00 | 4,574,475.96 | 37,524.04 | 99.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,750,000.00 | 2,684,340.00 | 65,660.00 | 97.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,750,000.00 | 2,684,340.00 | 65,660.00 | 97.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 36,550,000.00 | 36,544,889.00 | 5,111 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 36,550,000.00 | 36,544,889.00 | 5,111 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,185,925,500.00 | 488,808,763.58 | 697,116,736.42 | 41.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,185,925,500.00 | 488,808,763.58 | 697,116,736.42 | 41.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 14,403,300,000.0 | 14,148,383,897.53 | 254,916,102.47 | 98.2 |
| 220001 | Барилга байгууламж | 5,395,000,000.00 | 5,316,814,512.28 | 78,185,487.72 | 98.6 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 9,008,300,000.00 | 8,831,569,385.25 | 176,730,614.75 | 98.0 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 16,112,347,500.00 | 15,731,387,589.66 | 380,959,910.34 | 97.6 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 13,908,347,500.00 | 14,517,388,123.76 | (609,040,623.76) | 104.4 |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 13,908,347,500.00 | 14,517,388,123.76 | (609,040,623.76) | 104.4 |
| 36 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | 2,204,000,000.00 | 1,213,999,465.90 | 990,000,534.10 | 55.1 |
| 360001 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 2,204,000,000.00 | 1,213,999,465.90 | 990,000,534.10 | 55.1 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 720,382,626.83 | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 1,287,665,282.50 | - | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 15 | 15 | | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | | 100.0 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн алдааг залруулах зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|---------|-----------------------------------|-------|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Санхүүгийн программын 2024 оны лицензийн төлбөрийг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн | 1 | 1,040.0 | | | 1 | 1,040.0 | 1 | 1,040.0 | | | | |
| Тайлант хугацаанд худалдан авсан шатахууны картын хөнгөлөлтийг орлогоор бүртгээгүй, зардлыг бууруулж тайлагнасан | 1 | 264.7 | 1 | 264.7 | | | 1 | 264.7 | | | | |
| Домэйний 2024 онд ногдох эрхийн төлбөрийг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн | 1 | 247.0 | | | 1 | 247.0 | 1 | 247.0 | | | | |
| Байрны түрээсийн зардалд төлөх ёстой төлбөрөөр Засгийн газраас | 1 | - | 1 | - | | | | | 1 | - | 1 | - |

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|----------|----------------|----------|--------------|----------|----------------|----------|----------------|----------|----------------|----------|----------------|
| тус төсөлд оруулах мөнгөн бус оролцоог тооцож бүртгэх ёстой боловч бүртгээгүй байна | | | | | | | | | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд гадаад валютаарх санхүүжилтийн орлогын гүйлгээг илүү тайлагнасан байна | 1 | 3,497.5 | | | 1 | 3,497.5 | | | 1 | 3,497.5 | 1 | 3,497.5 |
| Зээл болон тусламжийн санхүүжилтийг арилжааны банкны тусгай дансаар дамжуулан төслийн дэд дансанд төвлөрүүлдэг бөгөөд тусгай дансны эхний болон эцсийн үлдэгдэл, орлого зарлагын гүйлгээг төслийн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна | 1 | - | 1 | - | | | | | 1 | - | 1 | - |
| Дүн | 6 | 5,049.2 | 3 | 264.7 | 3 | 4,784.5 | 3 | 1,551.7 | 3 | 3,497.5 | 3 | 3,497.5 |

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|--------------|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд дотоод томилолтын зардлын зам хоног, байрны зардлыг тогтоосон зардлын хэмжээнээс хэтрүүлсэн | 1 | 323.8 | 1 | 323.8 | | | | | | | | |
| Тайлант хугацааны эцэст тендерийн баримт бичиг борлуулсны орлогын зарцуулаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй | 1 | 408.7 | 1 | 408.7 | | | | | | | | |
| Дотоодын томилолтын төсвийг тухай бүрд нь боловсруулж, батлуулаагүй, 7 удаагийн болон 10 удаагийн томилолтыг нэгтгэн 2 төсөв боловсруулж батлуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тайлант хугацааны цалингаас тооцсон хувь хүний татварын хөнгөлөлтийг жилээр нь тулгахад хөнгөлөлтийг дутуу тооцоолж татварыг илүү ногдуулсан | 1 | 75.3 | | | | | 1 | 75.3 | | | | |
| Тайлант хугацаанд нэр бүхий дотоодын 2 зөвлөхийн ажлын хөлсийг олгохдоо гэрээний үүргийн дагуу ХХОАТ-ыг суутгаж, бүртгээгүй | 1 | 1,292.0 | | | | | 1 | 1,292.0 | | | | |
| Дүн | 5 | 2,099.8 | 2 | 732.5 | | | 3 | 1,367.3 | | | | |

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 15.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 15.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх оны шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжийг биелүүлээгүй | 1 | 14,975.3 | | | 1 | 14,975.3 | | |
| Өмнөх оны үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмжийг биелүүлээгүй | 1 | - | | | 1 | | | |
| ТХН-ийн ажилчдын цагийн бүртгэлийг албажуулаагүй | 1 | | | | | | 1 | - |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ТУХ нь тайлант онд нэг удаа хуралдсан | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 4 | 14,975.3 | | | 2 | 14,975.3 | 2 | - |